



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 06 сарын 11 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛИУДЫГ ХЭРЭГЛЭХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хуулийн 3³ дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “2021 оноос эхлэн тус бүр 9.5 хувьтай” гэснийг “2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл тус бүр 9.5 хувь, 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн тус бүр 8.5 хувьтай” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “2021 оноос эхлэн 12.5 хувиас” гэснийг “2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл 12.5 хувиас, 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн 11.5 хувиас” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдөр баталсан Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР